


## БАТЛАВ НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА

Ж.ГАНБОЛД

2015 он 4. сар 28. өдөр



# БАТЛАВ ТАЛЫН ДУУЛИАН” ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

# ИХ ТАЛЬЯН ДУУШАН ТББ

Д.ТЭРБААТАР

2015 он 11 сар 08 өдөр

## ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2015 оны 01 дүгээр  
сарын 28.-ны өдөр

No 91

Улаанбаатар  
хот

Энэхүү гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г нэг талаас Нийслэлийн Биеийн тамир, спортын газар /цаашид “НБТСГ” гэх/, түүнийг төлөөлж Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд, нөгөө талаас “Их талын дуулиан” ТББ /цаашид “ТББ”, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Д.Тэрбаатар, хамтад нь “Талууд” гэх/ нар хүүхэд, залуучуудын дунд зохион байгуулагддаг “Дуулиан-2020” тэмцээний хурээнд дараахи нөхцлөөр хамтран ажиллахаар харилцан тохиролцож байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Гэрээний зорилго нь НБТСГ нь 2014 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 2015 оны 03 дугаар сарын 29-ний өдрүүдэд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн дэмжлэгтэйгээр “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиуд болон залуучуудын дунд зохиогдох “Дуулиан-2020” заалны хөлбөмбөгийн ес дэх удаагийн тэмцээн /цаашид “Тэмцээн” гэх/-ий үеэр “АЛТАН ТҮНШ” хэмээн сурталчлуулах, гэрээнд заасан хэмжээгээр НБТСГ-ын үйл ажиллагааны талаар тэмцээний үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд сурталчилгаа явуулахад НБТСГ-ын нэрийг оруулан сурталчилхтай холбогdon үүсэх харилцаанд талуудын эрх, үүргийг тодорхойлно.

1.2. Талуудын харилцан бие биесийн байгууллагын нэр хүнд, эрх, ашгийг хүндэтгэн, ямарваа санал нийлэхгүй байгаа асуудлыг зөвшилцэж, энэхүү Гэрээгээр өөрийн хүлээсэн эрх, үүргийг сайн дурын үндсэн дээр биелүүлж ажиллахаа энэ Гэрээнд гарын үсэг зурснаар илэрхийлж байна.

## ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАВДАЛ

2.1. Энэхүү Гэрээний дагуу НБТСГ-аас “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх “Дуулиан-2020” тэмцээний тус хөтөлбөрт тусгагдсан зардал 82.970.000 /наян хоёр сая есөн зуун далан мянга/ төгрөг байхаар тохиролцов. Гэрээний зарцуулалтыг Хавсралт-1-ын дагуу зарцуулна.

2.2. НБТСГ нь Захирамж гарсны дагуу тэрхүү мөнгөн хөрөнгийг ТББ-ын дансанд Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ТББ-аас ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн ажлын 3 хоногийн дотор ХасБанкин дахь Их Талын Дуулиан ТББ-ын 5000285074 тоот дансанд шилжүүлнэ.

## ГУРАВ. ТББ-ЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. ТББ нь дараахь үүрэг хүлээнэ.

3.1.1. Өөрийн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулахдаа “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд НБТСГ-ын нийгмийн болон хүүхдийн ирээдүйн төлөө үйл ажиллагааг хамтран зохион байгуулж, хөлбөмбөгийн спортын уралдаан, тэмцээнийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах,

3.1.2. Нийслэлийн хөлбөмбөгийн шигшээ багийг байгуулан уралдаан тэмцээнд оролцох, бэлтгэл сургуулилтыг хариуцан ажиллана.

3.1.3. Нийслэлийн хүүхэд, багачуудын зуны амралтыг тохиолдуулан бүх нийтийн спортыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үйл ажиллагаанд гар бие оролцоно.

3.1.4. Хамтран зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд НБТСГ-ыг сурталчлахдаа

1/ “Дуулиан-2020” тэмцээний “АЛТАН ТҮНШ”,

2/ Нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа идэвхтэй хэрэгжүүлдэг,

2/ ТББ-ын эрхэм зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны байнгын дэмжигч, санхүүжүүлэгч,

3/ Хүүхэд, залуучуудын дунд спортыг хөгжүүлэх үйлсийг хэрэгжүүлэгч хэмээн сурталчлах үүрэгтэй.

3.1.5. НБТСГ-тай хамтран зохион байгуулсан үйл ажиллагаанд холбогдох тайланг үйл ажиллагаа дууссанаас хойш ажлын З хоногийн дотор ирүүлэх,

3.1.6. НБТСГ ажиллагсдад зориулсан тэмцээн, уралдааныг зохион байгуулахад хамтран оролцох, тэдгээрийн нийгмийн оролцоог идэвхжүүлэх ажлыг өөрийн болон НБТСГ-ын санаачилгаар зохион байгуулж байх,

3.1.7. ТББ-аас эрхлэн гаргаж буй мэдээллийн товхимол болон мэдээлэл сурталчилгаанд НБТСГ-ын эмблем /лого/-г үнэ төлбөргүй байрлуулж, НБТСГ-тай хамтран зохион байгуулсан үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нийтлэх, мэдээлэх,

3.1.8. Дүүргүүдийн дунд зохиогдох хөлбөмбөгийн холбогдолтой аливаа сургалт, тэмцээн уралдааныг хамтран зохион байгуулах,

3.1.9. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх,

3.2. ТББ нь дараахь эрх эдэлнэ.

3.2.1. Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар НБТСГ-аас ирүүлсэн мэдээллийг өөрийн үйл ажиллагаанд тусгах, мэдээлэл сурталчилгаандаа ашиглах,

3.2.2. Хамтран зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, тэмцээн уралдаанд оролцогчдод олгох НБТСГ-ын санхүүжилттай шагналын сан байгуулах, түүнийг захиран зарцуулах,

3.2.3. Дүүргүүдэд зохион байгуулах “Дуулиан-2020” тэмцээнийг НБТСГ-ын харьяа БТСХороодтой хамтран зохион байгуулах,

3.2.4. НБТСГ-аас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах,

## ДӨРӨВ. НБТСГ-ЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. НБТСГ нь дараахь үүрэг хүлээнэ.

4.1.1. Гэрээний 2.2-т заасны дагуу зардал шилжүүлэх,

4.1.2. ТББ-ыг өөрийн үйл ажиллагааны талаарх шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах,

4.1.3. ТББ гэрээний үүргээ зөрчсөнөөс бусад тохиолдолд ивээн тэтгэж шилжүүлсэн хөрөнгийг буцаан авах талаар ямар нэг шаардлага тавихгүй байх.

4.2. НБТСГ нь дараахь эрх эдэлнэ.

4.2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг ТББ-аас шаардах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих,

4.2.2. ТББ нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд гэрээний үнийн дүнг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн эргүүлэн шилжүүлэхийг шаардах,

#### ТАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

5.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс хүрвэл Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1. Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Гэрээний нөхцөл бүрэн хангагдсанаар дуусгавар болно.

6.2. Гэрээг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хадгалсан хувь бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

6.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, бичгээр нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,  
СПОРТЫН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

А.БОЛДМАА

“ИХ ТАЛЫН ДУУЛИАН” ТББ-ЫГ  
ТӨЛӨӨЛЖ:  
МЭРГЭЖИЛТЭН

Б.ГИВАА